

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт.....	12
4.3 Албан шаардлага .....	12
4.4 Зөвлөмж .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433081  
E-mail: khovd@audit.gov.mn

**МӨНХХАЙРХАНЫ БАЙГАЛИЙН  
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГА М.ОДХҮҮ ТАНАА**

2022.01.24 № 403  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

021020144

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>45,076,542.92</u>	<u>45,194,329.41</u>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	45,076,542.92	45,194,329.41
354	<b>Хангамжийн материал</b>	45,076,542.92	45,194,329.41
35410	Бичиг хэргийн материал	303,600	247,200
35420	Аж ахуйн материал	20,000	20,000
35440	Түлш, шатах тослох материал	1,480,000.00	489,189.25
35470	Бусад хангамжийн материал	43,272,942.92	44,437,940.16
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>177,198,637.87</u>	<u>138,278,198.56</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<u>177,198,637.87</u>	<u>138,278,198.56</u>
392	<b>Биет хөрөнгө</b>	174,940,637.87	135,828,198.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	71,065,931	71,065,931
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,537,514.18	-9,556,267.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,252,600	103,252,600
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,673,283.38	-64,924,150.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,305,267.38	71,642,767.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,109,734.27	-48,358,490.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,253,118.43	13,133,018.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,471,327.03	-5,574,884.70
39209	Зам, гүүрийн байгууламж	2,783,370	6,669,370
39210	Хуримтлагдсан элэгдэл	-927,790.08	-1,521,695.56
393	<b>Биет бус хөрөнгө</b>	2,258,000	2,450,000
39301	Программ хангамж	600,000	600,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	-120,000
39303	Бусад биет бус хөрөнгө	1,658,000	1,970,000
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>222,275,180.79</u>	<u>183,472,527.97</u>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<u>222,275,180.79</u>	<u>183,472,527.97</u>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	222,275,180.79	183,472,527.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	103,948,311.79	104,260,311.79
51101	Өмч: - төрийн	103,948,311.79	104,260,311.79
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	110,533,053.44	71,418,400.62
51210	Өмнөх үеийн үр дүн	110,533,053.44	110,533,053.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	-39,114,652.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,793,815.56	7,793,815.56
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<u>222,275,180.79</u>	<u>183,472,527.97</u>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	518,646,688.36	377,216,318.25
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	68,718,621.36	4,544,418.25
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	68,718,621.36	4,544,418.25
Төсөв байгууллагын өөрийн орлого	68,718,621.36	4,544,418.25
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,370,000.24	3,105,229
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	65,348,621.12	1,439,189.25
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	449,928,067.00	372,671,900.00
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	351,334,900	336,702,900

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	351,334,900	336,702,900
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>98,593,167</b>	<b>35,969,000</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	22,900,000
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,657,203	4,000,000
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,935,964	9,069,000
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>390,923,945.42</b>	<b>416,330,971.07</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>390,923,945.42</b>	<b>416,330,971.07</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>337,399,472.48</b>	<b>401,085,179.91</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>162,832,815</b>	<b>180,971,714</b>
Үндсэн цалин	127,818,285	127,513,333
Нэмэгдэл	29,918,630	47,689,381
Унаа хоолны хөнгөлөлт	5,095,900	5,769,000
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,460,581.30</b>	<b>30,484,905.84</b>
Тэтгэврийн даатгал	17,534,161	21,575,186.93
Тэтгэмжийн даатгал	2,062,841	2,404,151.57
ҮОМШӨ-ний даатгал	1,646,913	1,876,278.96
Ажилгүйдлийн даатгал	383,333.30	416,481.72
Эрүүл мэндийн даатгал	3,833,333	4,212,806.66
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,066,864</b>	<b>5,254,503</b>
Гэрэл, цахилгаан	698,364	476,003
Түлш, халаалт	3,343,500	4,671,700
Цэвэр, бохир ус	25,000	106,800
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,375,100</b>	<b>33,002,174</b>
Бичиг хэрэг	514,600	589,800
Тээвэр, шатахуун	32,090,300	30,141,348
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,888,100	1,949,126
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	767,100	321,900
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,781,600</b>	<b>2,205,900</b>
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	167,900
Урсгал засвар	1,581,600	2,038,000
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,567,000</b>	<b>2,942,000</b>
Дотоод албан томилолт	2,567,000	2,942,000
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>60,516,267.08</b>	<b>92,888,143.76</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,637,067.08	92,254,543.76
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000	148,720
Даатгалын үйлчилгээ	177,500	108,900
Тээврийн хэрэгслийн татвар	118,700	68,500
Тээврийн хэрэгслийн оношилгоо	39,000	57,700
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	249,780
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,799,245.10</b>	<b>53,335,839.31</b>
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,799,245.10	53,335,839.31
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,524,472.94</b>	<b>15,245,791.16</b>
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,910,472.94</b>	<b>15,245,791.16</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	51,910,472.94	15,245,791.16
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>127,722,742.94</u></b>	<b><u>(39,114,652.82)</u></b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>127,722,742.94</u></b>	<b><u>(39,114,652.82)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	103,948,312	7,793,816	110,533,053	222,275,181
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	103,948,312	7,793,816	110,533,053	222,275,181
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	103,948,312	7,793,816	110,533,053	222,275,181
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	312,000	-	-	312,000
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(39,114,653)	(39,114,653)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	104,260,312	7,793,816	71,418,401	183,472,528

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>453,298,067.24</u>	<u>375,777,129</u>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	3,370,000.24	3,105,229
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,370,000.24	3,105,229
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,370,000.24	3,105,229
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,370,000.24	3,105,229
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	449,928,067	372,671,900
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	351,334,900	336,702,900
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	351,334,900	336,702,900
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	98,593,167	35,969,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	22,900,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,657,203	4,000,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,935,964	9,069,000
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<u>453,298,067.24</u>	<u>375,777,129</u>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	453,298,067.24	375,777,129
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	399,773,594.30	360,531,337.84
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	162,862,825	180,971,715
210101	Үндсэн цалин	127,848,295	127,075,601
210102	Нэмэгдэл	29,918,630	48,155,614
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,095,900	5,740,500
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,358,446.30	24,085,180.84
210201	Тэтгэврийн даатгал	13,987,574.94	16,962,585.95
210202	Тэтгэмжийн даатгал	1,645,591.51	1,889,517.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,313,117.73	1,464,573.58
210204	Ажилгүйдлийн даатгал	310,195.73	338,230.62
210205	Эрүүл мэндийн даатгал	3,101,966.39	3,430,273.54
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,475,264.00	4,124,503.00
210301	Гэрэл, цахилгаан	848,364	776,003
210302	Түлш, халаалт	3,601,900	3,241,700
210303	Цэвэр, бохир ус	25,000	106,800
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,669,300	26,665,026
210401	Бичиг хэрэг	675,400	311,700
210402	Тээвэр, шатахуун	29,428,700	23,924,000

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,888,100	1,949,626
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	115,000	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	562,100	479,700
2105	<b>Нормативт зардал</b>	250,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,440,900	2,887,200
210601	Багаж, техник, хэрэгсэл	278,000	242,300
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	106,900	106,900
210604	Урсгал засвар	1,056,000	2,538,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,567,000	2,942,000
210702	Дотоод албан томилолт	2,567,000	2,942,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	167,656,859	118,855,713
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,777,659	118,222,113
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000	148,500
210803	Даатгалын үйлчилгээ	177,500	108,900
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,000	68,500
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,700	57,700
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	250,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,493,000	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,493,000	
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	53,524,472.94	15,245,791.16
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,614,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,614,000.00	
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	51,910,472.94	15,245,791.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,910,472.94	15,245,791.16

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	339,702,900	324,562,337.84
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	339,702,900	324,562,337.84
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	339,702,900	324,562,337.84
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	190,047,800	180,971,715
210101	Үндсэн цалин	135,690,300	127,075,601
210102	Нэмэгдэл	48,182,900	48,155,614
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,174,600	5,740,500
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,656,500	24,085,180.84
210201	Тэтгэврийн даатгал	18,054,500	16,962,585.95
210202	Тэтгэмжийн даатгал	1,900,500	1,889,517.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,520,400	1,464,573.58
210204	Ажилгүйдлийн даатгал	380,100	338,230.62
210205	Эрүүл мэндийн даатгал	3,801,000	3,430,273.54
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,290,900	4,124,503
210301	Гэрэл, цахилгаан	942,400	776,003
210302	Түлш, халаалт	3,241,700	3,241,700
210303	Цэвэр, бохир ус	106,800	106,800

2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,673,800	23,353,026
210401	Бичиг хэрэг	311,700	311,700
210402	Тээвэр, шатахуун	20,612,000	20,612,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,270,400	1,949,626
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	479,700	479,700
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	349,200	349,200
210601	Багаж, техник, хэрэгсэл	242,300	242,300
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	106,900	106,900
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,318,100	2,242,000
210702	Дотоод албан томилолт	2,318,100	2,242,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	93,366,600	89,436,713
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,733,000	88,803,113
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500	148,500
210803	Даатгалын үйлчилгээ	108,900	108,900
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,500	68,500
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57,700	57,700
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000	250,000
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	339,702,900	324,562,337.84
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	336,702,900	321,457,108.84
131001	Улсын төсвөөс санхүүжих	336,702,900	321,457,108.84
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	3,000,000	3,105,229
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000	3,105,229
610001	Төсвийн байгууллага	01	01
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	18	18
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	03	03
620004	Гэрээт ажилтан	08	08
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14	14
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	04	04
650010	Гэрээт ажилтан	08	08

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	98,582,195	35,969,000
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	98,582,195	35,969,000
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	96,968,195	35,969,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,145,000	3,312,000
210402	Тээвэр, шатахуун	900,000	3,312,000
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,056,000	2,538,000
210604	Урсгал засвар	1,056,000	2,538,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	-	700,000
210702	Дотоод албан томилолт	-	700,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	87,253,231	29,419,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,253,231	29,419,000

II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	98,593,167	26,900,000
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	98,593,167	26,900,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,657,203	26,900,000

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 01 дүгээр сарын 21-нээс 2021 оны 01 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөнххайрханы Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь “Монгол Алтайн нурууны мөнх цас, мөсөн гол, түүнд зохицон шүтэж амьдрах биологийн төрөл зүйлүүд, ховор амьтан, ургамлыг хамгаалах, амьдрах орчныг хадгалан үлдээх, улмаар даян дэлхийд гарч буй байгаль орчны өөрчлөлтийг хянах, мэдээлэл солилцох, судалгаа шинжилгээ явуулах, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх оновчтой менежментийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биологийн олон янз байдал тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, популяцийн тоо толгойг тэнцвэрт хэмжээнд хадгалах
- Бэлчээрийн дарамтыг бууруулах, газрын тогтвортой менежментийг бий болгох
- Ойн нөөц, ус, усны орчныг хамгаалах, зохистой ашиглах тэнцвэрт байдлыг хадгалах
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх замаар голлох экосистемүүдийг хамгаалалтад авч үйл ажиллагааг нь сайжруулах
- Түүх соёлын өвийг хадгалан хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх
- Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан замаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоо Байгаль орчны яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххайрханы Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 375771.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Мөнххайрханы Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,802.6 мянган төгрөгөөр буюу 17.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 45,194.3 мянган төгрөг болж 117.8 мянган төгрөгөөр буюу шатахууны үнийн хөнгөлөлтөөр олгосон шатахууныг зарцуулаагүйтэй холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 60,212.8 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас үзүүлсэн хөнгөлөлт 439,2 мянган төгрөгөөр, БОАЖЯ-аас 1,000.0 мянган төгрөгийн гэрээт байгаль хамгаалагчийн

ажлын хувцас нийт 61,652.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 61,534.2 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 177,198.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 183,472.5 мянган төгрөг болж 38,920.4 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна .

Тайлант онд 14,415.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй хүлээн авсан, акталж устгасан хөрөнгөгүй ба тайлант оны эцэст 183,472,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 222,275.1 мянган төгрөг байсан оны эцэст 183,472.5 мянган төгрөг тайлант онд 38,802.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 39,114.6 мянган төгрөгийн алдагдалтай, Хөх нуурын нарийн үзүүрт байрлах газарт 195 мквт газрыг 30 жилийн хугацаатайгаар эзэмших гэрчилгээ олгогдож 312.0 мянган төгрөгөөр засгийн газрын сан дансанд бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Мөнххайрханы Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 388,573.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 388,573.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Байгаль орчны яамнаас тус байгууллагын төсвийг 339,702.9 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 339,702.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 336,702.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 339,702.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,105.2 мянган төгрөг нийт 339,808.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 324562.3 мянган төгрөгийг зарцуулж 15245.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 324,562.3 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,647.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 166.4, бараа хангамж, бараа материалын зардал 320.8, томилолтын зардал 76.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,929.9 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны давсан орлогын 105.2 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 3,105.2 мянган төгрөг буюу 3.5 хувиар давуулж биелүүлж орлогыг 15,245.7 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар Дэлхийн байгаль хамгаалах сангаас 22,900.0, үндсэн үйл ажиллагааны орлогоор 9,069.0 мянган төгрөг, БОАЖЯ, ДБХС-гийн хамтарсан гэрээний дагуу 4,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэлгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 17, зарлагын 2 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан боловч оны эцэст татан төвлөрүүлсэн 1 ажил гүйлгээг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 304.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж, 4,202.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 50 хувьтай хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 20,753.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16,963.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 216.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3,574.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шатахууны хөнгөлөлтийн урамшууллыг орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогоор бүртгээгүй, бараа материалын тайланд орлого аваагүй, үлдэгдлээр тусгаагүй 1,278.4 мянган төгрөг,
2. Газар эзэмших гэрчилгээтэй газрын үнэ төлбөргүйгээр орлогоор бүртгэж Засгийн газрын сан данс бүртгээгүй, тайлант үеийн үр дүн зөрүүтэй тайлагнасан 439.2 мянган төгрөг,
3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн мөнгөөр тохируулах бичилт хийгээгүй 15,245.8 мянган төгрөг

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 16,963.4 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 01 дүгээр сарын 24-ны 8 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

#### 4.2 Төлбөрийн акт

1. Томилолтоор ажилласан хугацааны томилолтын мөнгө олгохдоо унаа хоолны хөнгөлөлтийг суутган тооцоогүй 216.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн хуулийн заалт, аудитын "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.4.1 ***Дотоод хяналттай холбоотой асуудал***

**Илрүүлэлт:** Дотоод хяналтын баг хийх ажлын төлөвлөгөөгүй хяналт хэрэгжүүлээгүйгээс жолоочийн тооцооны хуудсанд тухайн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, томилолтын мөнгийг олгохдоо бүрэн бус анхан шатны баримтаар 3,574.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргасан зөрчил илэрлээ.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа	5	20,753.9	3	16,963.4	1	216.0	0	0	1	3,574.5

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОГДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АХЛАХ АУДИТОР:  Д.НАРАНТУУЛ

